

## ХОТЫН ЗАХИРГААНЫ САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ЭРХ ҮҮРЭГ БА АЖЛЫН ДОТООД ДҮРЭМ

### ОРШИЛ

Улсын санхүүгийн бодлого төлөвлөгөөг хэзээ нэгэн цагт сайтар биелүүлэх явдалд өөрийн эрх үүргийг хангалттай гүйцэтгэснээр тус улсын тусгаар тогтносон эрх чөлөөт байдал ба улс орныг батлан хамгаалах хүчин чадлыг зузаатгах, аж ахуй улс төрийн зорилтуудыг шийдвэрлэн биелүүлэх явдлын нэгэн зангилгаа нь мөн болох явдалд оршмуй.

### ТУС САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ЭРХ ҮҮРЭГ НЬ

1. Үндсэн хуулийн ёсоор тус Улаанбаатар хотын захиргааны байгуулалтад багтаж аппаратын орон тоо ба бүх ажил төрлийн хувьд хотын захиргааны даргад шууд захирагдмуй.
2. Хотын захиргааны ба жинхэнэ харьяа газрын орлого ба зарлагын ангийг удирдан төлөвлөх ба нэгтгэгч болмуй.
3. Тухайд төсөвлөсөн орлого зарлагыг нарийн чандаар бүртгэн тодорхойлж нэгэнтээгүүр хэмнэн зарцуулах ба орлогыг хэтэртэл биелүүлэх явдалд өөрийн шийдвэрээр зааврыг баримтлан ажиллах тухай зохион байгуулж удирдах ба зааварлах эрх бүхий болмуй.
4. Санхүүгийн хувьд өөрийн харьяаны зарцуулах эрх бүхий ба бусад газруудыг даруйд шалган шинжилж байцаагаад тодорхой акт семинараар уг тогтоолыг илрүүлэн гаргаж улам бүр сайжруулах тухай эрс арга хэмжээ авах эрхтэй болмуй.
5. Албан ба энгийн этгээдэд ноогдуулсан олон зүйлийн албан татварууд нь гүйлгээ тооцоогоор буюу хууль зүйлд эс тохирч, харшлах шалтгаан буй эсэхийг шалган хянаж батлах эрхтэй болмуй.
6. Албан татварын биелэлт хэрхэн болох тухай татвар хураалгагч албан ба энгийн этгээд нарын дунд нийтээр зохих шалгалтыг үргэлжлэн явуулж, тухайн эрхэлсэн тогтоол дээр эрс арга хэмжээ авах явдлыг зохион байгуулж ажиллах эрх бүхий болмуй.
7. Албан ба энгийн этгээдүүдээс татварын талбар ба бусад зүйлүүд талбар санхүүгийн хувьд гомдол мэдүүлсэн өргөдөл бичгийг зааврын ёсоор богино хугацаанаа барагдуулан дуусгах тухай зохих газраа уламжлах буюу актаа дуусгах эрхтэй болно.
8. Санхүүгийн талбар аливаа нэгэн гүйцэтгэх ажил ба ялангуяа орлого зарлагын явдал дээр зохих удирдлагуудаас санхүүгийн зааварт үнэндээ тохирмооргүй, тийм нэгэн тушаалыг зарим үед өгч гүйцэтгэсүгэй хэмээх аваас тухайн байдлаар шууд буюу түр татгалзах саналаа гэдрэг ирүүлэх ба ер ч улсын санхүүгийн хянан байцаах газраа мэдүүлж, нэгэн тийш заан тогтоолгох эрхтэй баймуй.
9. Өөрийн хэлтсийн харьяа ерөнхий нягтлан бодох ба албан татварын байцаагчийг шууд харьяалан захирч, ажил дээр нь хариуцлагатай болгох тухай зөвөөр удирдах ба зааварлаж сайнаар сургаж үүргийг хүлээвээс зохимуй.

## **ТУС ХЭЛТСИЙН АЖИЛ ТӨРЛИЙН ХУВЬД ХОЁР АНГИЛАХ, ҮҮНД:**

1. Орлого ба байцаагч хэсэг
2. Зарлага ба нягтлан бодох хэсэг, эдгээр хоёроор хэсэглэсэн тул байцаагч нарын эрх үүргийг хавсаргавай. Нягтлан бодох нь ерөнхий ба ахлах нягтлан бодох нарын дүрмийн баримталж, ажилласугай.

## **САНХҮҮГИЙН БАЙЦААГЧ НАРЫН ЭРХ ҮҮРГИЙН ТУХАЙ**

1. Улсын дагаж шийтгүүлэн буй олон зүйлийн албан татваруудыг тухайн хууль зааврын ёсоор хэрхэн зөвөөр ёсчлон биелүүлж буй явдлыг цаг үргэлж хянаж шалгаж байх ба зааварлах үүрэг бүхий болно.
2. Албан хийгээд энгийн газар хүмүүсийн аливаа орлогын зүйлийг эрхлэн хураалгах ба зохих цаг хугацааны дотор хэрхэн төлж гүйцэтгэж хуулийг биелүүлэн буйг хянаж шалгах ба тухайд ноогдуулах эрх бүхий болно.
3. Аливаа нэгэн албан татвар хураалгагч албан ба энгийн газар хүмүүсүүдийн тухайн орлогыг хураах явдалд түүнийг зөрчигсөд илрэн гаргах ахул акт баримтыг үйлдэж харьяат санхүүгийн хэлтсийн даргад илтгэж арга хэмжээ авахуулах үүрэг бүхий болно.
4. Аливаа албан татварын ба бусад төрөл бүрийн орлогын тогтоолыг тухайн хууль ёсоор нэхэмжлэн шаардаж төлүүлэх үүрэг бүхий болой.
5. Хууль зааврын ёсоор албан татваруудын зохих данс тайланг тодорхойгоор хөтлөх ба эцэст тухайн акт мэдээг нарийн тодорхойгоор үйлдэх ба ер ч тэр газрууд хийгээд хүмүүсийн энэ тухайн холбогдол бүхий данс тайланг хэзээ ч болбол хянан үзэх эрх бүхий болно.
6. Байцаагч хүн нь албан татварын хувь бусад орлогын мөнөөхөн зүйлийг өөрийн биед хүлээн авах эрхгүй болно.
7. Албан татварын байцаагч нараас өөрийн бүхий л хийж гүйцэтгэсэн ажлын тухай харьяат хэлтсийн даргад илтгэх ба түүний өмнө бүрэн хариуцаад үүрэг бүхий болно.
8. Байцаагч нар нь албан татварын тухай хяналт шалгалтын ажлыг явуулахдаа зохих үнэмлэхийг биедээ бэлхнээ авч явбаас зохимуй.
9. Байцаагч нар нь энэхүү үнэмлэхээр олгогдсон эрх үүргийг бусдадаа шилжүүлж хэрхэвч үл болно. Хэрэв ажлаас нь халагдах ба шилжих ахул уг үнэмлэхийг санхүүгийн хэлтэст хураалгаж гүйцэтгэх үүрэг бүхий болно.
10. Байцаагч нар нь санхүүгийн хэлтсийн дарга ба хууль хамгаалах газруудын эрх баригчид лугаа ойрын харилцаатай байж тэд нарын тусламж үргэлжлэн хүлээж ажиллах явдлыг умартаж үл болно.

Б. Цохилоо